

**Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн
даргын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын хэрэгжилтэд
хяналт-шинжилгээ, үнэлгээ хийсэн ажлын тайлан**

/2016 оны жилийн эцсийн байдлаар/

2015.12.19

ЗТХЯ-ны ТНБД-ын 116 тушаалын 224 үүрэг даалгаврыг хяналтад авч, хэрэгжилтийн явцад 2016 оны жилийн эцсийн байдлаар хяналт-шинжилгээ, үнэлгээ хийлээ.

Хяналтад байгаа нийт үүрэг даалгаврын 106 нь биелсэн, 54 арга хэмжээ 90%, 16 арга хэмжээ 70%, 16 арга хэмжээ 50%, 6 арга хэмжээ 30%, 4 арга хэмжээ хэрэгжээгүй буюу биелэлтээ ирүүлээгүй, 8 арга хэмжээний хэрэгжүүлэх хугацаа болоогүй, 14 арга хэмжээ тушаалаар хүчингүй болсон, нийт **86,9** хувийн биелэлттэй байна.

ТНБД-ын тушаалаар өгөгдсөн үүрэг даалгаврын биелэлтийг хариуцан хэрэгжүүлэх газар тус бүрээр нь гаргавал дараах байдалтай байна. Үүнд:

№	Газрын нэрс	Нийт заалт	Үүнээс /хувиар/								Хүчингүй болсон	Биелэлт хувь
			100	90	70	50	30	10	хэрэгжээгүй, биелэлт ирүүлээгүй	Хугацаа болоогүй		
1	БТГ	81	30	5	8	7	1	-	1	1	8	86,0
2	ТЗУГ	67	16	9	6	4	1	-	1	5	5	85.3
3	ХШУДАГ	74	23	1	6	2	3	-	-	1	8	87.7
4	АЗБХЗГ	73	47	9	5	-	-	-	-	1	1	95.2
5	АТБХЗГ	28	6	6	3	2	-	-	-	-	1	87.0
6	ТЗДТБХЗГ	44	23	5	-	3	1	-	1	-	1	89.1
7	АТБХЗХ	19	3	3	2	-	-	-	-	-	1	89.4
8	ИНЕГ	3	2	-	1	-	-	-	-	-	-	90.0
9	ЗТХТ	3	2	1	-	-	-	-	-	-	-	96.7
10	АТҮТ	4	1	1	1	-	-	-	-	-	1	86.7
11	ГТХЗНТ	1	1	-	-	-	-	-	-	-	-	100.0
12	УБТЗ	10	9	-	-	-	-	-	1	-	-	90.0
13	төслийн нэгж	8	2	-	1	2	1	-	1	1	-	57.1
	Нийт	224	106	54	16	16	6	0	4	8	14	86.9

ТНБД-ын 2012 оны 1, 2013 оны 7, 2014 оны 3, 2015 оны 29 тушаал хэрэгжиж дуусаагүй хяналтад байгаагаас 9 нь байнгын хяналтад байх журам баталсан тушаал, 4 нь дунд хугацааны хөтөлбөр, төлөвлөгөө баталсан, 6 нь байнгын ажиллагаатай ажлын хэсэг, комисс томилсон тушаал байна.

Хяналтад байгаа 224 үүрэг даалгаврын 66 нь хугацаатай үүрэг даалгавар байгаагаас 42 нь хэрэгжиж, 24 үүрэг даалгавар хэрэгжилтийн хугацаа хэтэрсэн байна.

90 хувийн хэрэгжилттэй 54 заалтын 35 нь байнгын хяналтад байх арга хэмжээнүүд байна.

Хэрэгжих хугацаа хэтэрсэн заалтууд:

№	Шийдвэрийн нэр, огноо, дугаар	Хэрэгжүүлэх заалт	Хэрэгжүүлэх газар, хэлтэс, хугацаа
1.	Ажил үүрэг хариуцуулах тухай 2012.09.25 №34	1.Засгийн газрын бүтцийн өөрчлөлтөөр татан буугдсан харьяа агентлагуудын ашиглаж байсан баримт бичгүүд болон архивын материалуудыг Үндэсний төв архивт 2012.12.01-ний өдрийн дотор албан ёсоор хүлээлгэн өгөхийг татан буугдсан АЗГ-ын архив, бичиг хэргийн ажилтан Ж.Тунгалаг, АТГ-ын бичиг хэргийн ажилтан С.Нансалмаа, ЗТЯны бичээч-операторчин З.Хандсүрэн нарт тус тус үүрэг болгосугай.	ТЗУГ 2012.12.31
2.	Ажлын хэсэг томилон ажиллуулах тухай 2013.03.11 №89	2.Татан буугдсан Төмөр замын газрын архивын баримтыг цэгцлэх ажлыг 2013.03.20-ны дотор хийж гүйцэтгэн байгууллагын архивын ажлын үндсэн зааврын дагуу бүртгэл үйлдэж, УАГ-ын дэргэдэх БНШАЗК-ын хурлаар хэлэлцүүлэх батлуулахыг ажлын хэсгийн гишүүдэд үүрэг болгосугай. Нбд –З.Хандсүрэн	ТЗУГ 2013.03.20
3.	Ажлын хэсэг байгуулах тухай 2015.07.22 №264	2.Хуулийн хүрээнд ажлыг шуурхай зохион байгуулж, Ажил хүлээлцсэн актыг үйлдэн 2015.08.20-ны дотор яамны удирдлагад танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Я.Мөнхжаргал/-д даалгасугай. /400 автобусыг дизель-хийн түлшний хосолмол хэрэглээнд шилжүүлэх, тоног төхөөрөмж нийлүүлэх, угсарч суурилуулах ажлын гэрээг дүгнэж, дуусгавар болгох ажлын хэсэг/ нбд-Д.Ариунтуяа	АТБХЗГ 2015.08.20
4.	Комисс томилох тухай 2015.11.13 №438 /2016.03.02-ны №64 тушаалаар өөрчлөлт оруулсан/	2. МУ-ын ЗГ-ын 2012 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан "Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм", ЗТС-ын 2015 оны 277 дугаар тушаалын дагуу комиссын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллахыг комиссын дарга /П.Билгүүн/-д үүрэг болгосугай. /ОУ-ын шинэ нисэх буудлын хамгаалалтын далангийн барилгын ажлыг хүлээн авч ашиглалтад оруулах комисс/ нбд-П.Сүхболд	ХШҮДАГ ИНЕГ 2015.11.12 -13
5.		5.Тайланг 2015.11.20-ны дотор багтаан яамны удирдлагад танилцуулсугай.	ХШҮДАГ 2015.11.20
6.	Ажлын хэсэг шинэчлэн байгуулах тухай 2015.12.08 №502	3. Төлөвлөгөөний төслийг төмөр замын тээврийн тухай хууль тогтоомж, олон улсын гэрээ хэлэлцээр, бодлогын баримт бичиг болон төмөр замын тээврийн дунд болон ойрын хугацааны хөгжлийн чиг баримжаанд тулгуурлан тооцоо, судалгаанд үндэслэн боловсруулж, 2016.03.01-ний дотор СЗХ-аар хэлэлцүүлэхийг Ажлын хэсэг /Б.Артур/-т үүрэг болгосугай. /Төрөөс төмөр замын тээврийн талаар баримтлах бодлогын хэрэгжилтэд санал дүгнэлт гаргах, бодлогыг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж батлуулах ажлын хэсэг/ нбд-Г.Баттуяа	ТЗДТБХЗГ БТГ 2016.03.01
7.	Ажлын хэсэг байгуулах тухай 2016.03.14 №84	2. Хүлээлгэн өгөөгүй байгаа тоног төхөөрөмж, програм хангамжийг АТҮТ ТӨҮГ-т хүлээлгэн өгөхдөө хурлын протокол, акт зэрэг үйлдэж, 2016.04.01-ний дотор багтаан танилцуулахыг Ажлын хэсэг /П.Билгүүн/-т үүрэг болгосугай. /ЗТЯ, Болгар улсын "Контракс ЕАД" компанитай байгуулсан "Тээврийн хэрэгслийн бүртгэл, хяналтын нэгдсэн системийн тоног төхөөрөмжийн угсралт, суурилуулалт, туршилт тохируулгын ажил" 45/А тоот гэрээ хэрэгжиж дууссантай холбогдуулан хүлээлгэн өгөөгүй байгаа тоног төхөөрөмж, програм хангамжийг АТҮТ ТӨҮГ-т хүлээлгэн өгөх ажлын хэсэг/ нбд-Н.Уугандулам	ХШҮДАГ 2016.04.01
8.	Дэд ажлын хэсэг томилох тухай 2016.05.09 №165	2. "УБ хотын олон улсын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-д оролцогчоос ирүүлсэн техникийн болон санхүүгийн саналыг судлан санал дүгнэлтээ бэлтгэж, 2016.05.12-ны дотор МУ-ын Ерөнхий сайдын 2015 оны 209 дүгээр захирамжаар томилогдсон "УБ хотын оу-ын нисэх онгоцны шинэ буудлын менежмент төсөл"-ийг хэрэгжүүлэх санал тавьсан этгээдтэй хэлэлцээ хийх үүрэг бүхий ажлын хэсэгт танилцуулахыг Дэд ажлын хэсэг /С.Мөнхнасан/-т даалгасугай. нбд-Ч.Бадмаараг	АТБХЗХ Төслийн нэгж 2016.05.12
9.	Ажлын хэсэг байгуулах тухай 2016.05.23 №188	3. Ажлын хэсгийн дүгнэлт тайланг СЗХ-аар хэлэлцүүлж, цаашид хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулахыг ажлын хэсгийн дарга /Н.Ганибал/-д үүрэг болгосугай. /ЗТХТ ТӨҮГ-ийн үйл ажиллагаанд дүгнэлт гаргах/ нбд-Л.Батсүх	ТЗУХЭЗГ 2016.05.30
10.	Тооллогын комисс томилох тухай 2016.07.04 №230	2. Эд хөрөнгийн тооллогыг 2016 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс эхлэн ажлын 10 өдөр дотор багтаан гүйцэтгэж, 2016 оны 07 дугаар сарын 20-ны дотор танилцуулахыг Тооллогын комисс /Ч.Ренчиндамба/-т үүрэг болгосугай. /Яамны 2016 оны эхний хагас жилийн үндсэн болон эргэлтийн хөрөнгийн тооллого/ нбд-Б.Саруултөгс	БТГ 2016.07.20
11.	Комисс томилох тухай 2016.09.28 №111	2. МУ-ын ЗГ-ын 2012 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан "Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм", ЗТСын 2015 оны 277 дугаар тушаалын дагуу комиссын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах, комиссын тайланг 2016.10.14-ний өдрийн дотор танилцуулахыг комиссын дарга /Т.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай. /Хөгжлийн банкны хөрөнгө оруулалтаар баригдсан Халзанбүргэдэй-Солонготын даваа чиглэлийн 100 км авто замын үлдэгдэл 58 км хатуу хучилттай автозамын барилгын ажлыг ашиглалтад авах/ нбд-Б.Гийвийшинэн	АЗБХЗГ ХШҮДАГ 2016.10.14
12.	Комисс шинэчлэн байгуулах тухай 2016.10.25 №140	2. МУ-ын ЗГ-ын 2012 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан "Барилгын ажил эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтад оруулах дүрэм", ЗТС-ын 2015 оны 277 дугаар тушаалын дагуу комиссын үйл ажиллагааг зохион байгуулж ажиллах, комиссын тайланг 2016.11.09-ний өдрийн дотор танилцуулахыг комиссын дарга /Т.Гомбосүрэн/-д үүрэг болгосугай. /Замын-Үүдийн шалган нэвтрүүлэх боомтын 9.6 км хатуу хучилттай автозам, талбайн барилгын ажлыг ашиглалтад авах/ нбд-У.Эрдэнэбаатар	ХШҮДАГ 2016.11.09
13.	Ажлын хэсэг байгуулах тухай 2016.11.16 №166	3. Хэлэлцээ хийх, нэмэлт гэрээ байгуулах ажлыг холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн хийж, үр дүн, цаашид арга хэмжээний саналыг 2016.11.25-ны дотор танилцуулахыг Ажлын хэсгийн ахлагч /Д.Доржханд/-д даалгасугай. /Барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаа нэг жил/ Нбд-Л.Баянзул, А.Гантулга	АЗБХЗГ 2016.11.25

Санал, зөвлөмж:

1. Газар, хэлтэсүүд хэрэгжүүлэх хугацаа хэтэрсэн болон удаашралтай хэрэгжиж байгаа (ялангуяа 2012-2015 оны) үүрэг даалгаврыг ойрын хугацаанд хэрэгжүүлж дуусгах;
2. Хүчин төгөлдөр үйлчилж байгаа өмнөх тушаалыг хүчингүй болголгүй дараагийн тушаал гаргах, ажлын хэсгийн ахлагч, нбд ажлаас чөлөөлөгдсөнөөс тухайн ажлын хэсгийн ажил удааширч хугацаа алдах тохиолдол гарч байгаа тул ТЗУГ-ийн хуулийн мэргэжилтнүүд тушаалын төслийг хянахдаа энэ талаар анхаарч ажиллах, тухайн асуудлыг хариуцсан мэргэжилтэн ажлаас чөлөөлөгдсөн тохиолдолд тушаалд тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулж байх, байнгын ажиллагаатай ажлын хэсгийн ахлагч, нарийн бичгийн дарга, гишүүдийг албан тушаалын нэрээр томилж байх;
3. Тушаалын биелэлтийг тайлагнах үед харьяа байгууллага, яамны газар, хэлтсийн мэргэжилтнүүд өөрт холбоотой тушаал шийдвэр гарсныг мэдээгүй гэх гомдол байнга гарч байгаа тул тушаал боловсруулан гаргасан ажилтан тухайн тушаалаар үүрэг өгөгдсөн байгууллага, албан тушаалтанд тушаалыг “Зам, тээврийн хөгжлийн яамны албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааны журам”-ын дагуу албан ёсоор хүргүүлж хэвших, ТЗУГ-аас хяналт тавьж ажиллах;
4. ТНБД-ын тушаалаар батлагдсан дотоод дүрэм, журмуудын өөрчлөлтүүдийг тухай бүр оруулж, кодификаци хийн яамны вэб хуудсанд тавьж, нийт хэрэглэгчдэд мэдэгдэж хэвших;
5. Хэрэгжүүлэх боломжгүй болсон, ач холбогдлоо алдсан тушаалуудыг хүчингүй болгох;
6. Тухайн асуудлыг хариуцсан газар, хэлтсүүд нь байхад дахин ажлын хэсэг байгуулж, үүрэг өгч байгаа нь олон газар, хэлтсийн дунд ажил цалгардуулах талтай байгаа тул онц шаардлагатай тохиолдолд ажлын хэсэг байгуулж байх;
7. Тодорхой хугацаа зааж үүрэг даалгавар өгч гаргасан тушаал цөөн байгаагаас хэрэгжилтийн явцад үнэлгээ өгөхөд хүндрэлтэй байгаа тул тухайн үүрэг даалгаврыг ямар хугацаанд хэрэгжүүлж дуусгахыг тушаалд заавал тусгаж байх;
8. Тайлан мэдээгээ цаг хугацаанд нь бүрэн ирүүлэх, үнэн зөв, алдаагүй тайлагнах талаар газар, хэлтсийн дарга нар мэргэжилтнүүдэд үүрэг даалгавар өгч, хяналт тавих, ийм алдаа дутагдал дахин гаргасан тохиолдолд хариуцлага тооцож ажиллах;

Зөвшөөрсөн:

ЗТХЯ-ны ТНБД

Ж.Бат-Эрдэнэ

Хянасан:

ХШҮДАГ-ын ДҮТОГ

Т.Гомбосүрэн

Боловсруулсан:

ХШҮДАГ-ын ахлах мэргэжилтэн

Д.Баярмаа